



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 09 сарын 27 өдөр

Дугаар 4/608

Арвайхээр

Төсвийн орлого нэмэгдүүлэх, татвар
хураалтын ажлыг эрчимжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1. "е", Монгол Улсын автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, 8 дугаар зүйлийн 8.2 дахь заалтыг тус тус үндэслэн орон нутгийн төсөвт төвлөрүүлэх автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар, агаарын бохирдлын төлбөр, орон нутгийн төсөв төвлөрүүлэх ажлыг эрчимжүүлэх зорилгоор ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар, агаарын бохирдлын төлбөр, орон нутгийн зам ашигласны хураамж, бусад орлогыг ард иргэдэд сурталчилах, албан татварын хууль, хувь хэмжээг таниулах ажлыг зохион байгуулах, татварын орлогын төлөвлөгөөг жигд ханган биелүүлж, татвар хураалтын ажлыг эрчимжүүлэхийг аймгийн Татварын хэлтэс (Н.Эрдэнэсүвд)-т үүрэг болгосугай.

2. Орон нутгийн хэмжээнд хяналт, шалгалтын цэгүүдэд хамтарсан ажлын хэсэг гаргаж, автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар, агаарын бохирдлын төлбөр, орон нутгийн зам ашигласны хураамж, замын хөдөлгөөний болон хэв журмын зөрчил гаргаж торгуулийн мөнгөө хуулийн хугацаанд төлөөгүй иргэн, хуулийн этгээдийн зөрчлийг газар дээр нь арилгаж, орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхийг Цагдаагийн газар (хурандаа О.Ганбат), Татварын хэлтэс (Т.Эрдэнэсүвд) -т тус тус үүрэг болгосугай.

3. Дээрх арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулж, дүн мэдээг 2019 оны 11 дүгээр сарын 20-ны дотор танилцуулахыг аймгийн Цагдаагийн газар (хурандаа О.Ганбат), Татварын хэлтэс (Т.Эрдэнэсүвд) нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011101119